

ХОТ БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:							
<i>2.3. ЗГҮАХ-ийн 3.7.2, НЗДҮАХ-ийн 6.1.3, НХТЖҮЧ-ийн 9.3, НХЖТ-ний 6.1.8. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.</i>							
1	2.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох	200.0	Геопортал, гар утасны аппликейшн нэвтрүүлсэн эсэх	50	100	<p>1. Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 2022 оны А/170 дугаар захирамжийн дагуу “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох” ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулан, шалгарсан Смартдата ХХК-тай 2022 оны 5 дугаар сарын 9-ний өдөр НХААГ/202212160 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.</p> <p>2. Гэрээний дагуу компанийн албан хаагчидтай уулзалт хийж, байгууллагын хэмжээнд ашиглаж буй одоогийн систем, мэдээллийн сангийн талаар танилцуулж, геопорталын загварын саналыг хүргүүлж, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрт өгч хамтран ажиллаж байна.</p>	100

2	2.3.2.Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн “Улсын хаягийн нэгдсэн систем”-д бүрэн холбох	184.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	20	100	<p>1. Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2022 оны А/170 дугаар захирамжийн дагуу “Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн, Улсын хаягийн нэгдсэн системд холбох” ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулан, шалгарсан “Ай Си Ти групп” ХХК- тай 2022 оны 5 сарын 9-ны өдөр НХААГ/202212160 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан.</p> <p>2. Гэрээний дагуу компаний албан хаагчидтай 4 удаа уулзалт хийж, одоо ашиглаж байгаа нийслэлийн хаягийн мэдээллийн сангийн бүтэц, загвар, үйл ажиллагааны дарааллыг танилцуулсан. Гүйцэтгэгч компани нь улсын хаягийн системтэй холбоход зайлшгүй шаардлагатай системийн өгөгдлийн бааз, холболт, програм хангамжийн суурь судалгааг хийж байна.</p>	100
<i>Хоёр . Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд:</i>							
<i>Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:</i>							
2.1	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<p>1. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийн, үйлчилгээний тоон мэдээг 14 хоног тутам, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг I дүгээр улирал, эхний хагас жилийн байдлаар нэгтгэж ажиллав.</p> <p>2. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөө, Нийслэлийг 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний хэлтсийн хагас жилийн хэрэгжилтийн биелэлтийг тус тус нэгтгэж Захиргаа, санхүүгийн хэлтэст өгөв.</p>	
<i>Хот байгуулалтын кадастрыг эрхлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ</i>							
1	2.11. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, талбай, хотхон	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02/01, Гал сөнөөгчдийн	100

	хорооллыг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулах					холбооны 2021 оны 130 дугаартай тус тус албан бичгээр Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Цэцэг төвийн уулзвараас ерөнхий боловсролын V дугаар сургууль хүртэлх Бага тойруугийн гудамжийг “Гал сөнөөгчдийн гудамж” гэж өөрчлөн нэршүүлэх хүсэлтийг ирүүлсэн. Үүний дагуу гудамжны нэр өөрчлөх боломжгүй ба шинээр бүтээн байгуулалт хийгдэж байгаа авто замыг нэршүүлэх боломжийг судлан танилцуулж 2022 оны 01 дүгээр сарын 05 өдрийн 04/25 дугаартай албан бичгээр гал унтраах аврах ангиудын байршил бүхий зураг бэлдэж хүргүүлсэн. Үүний дагуу ХУД-ийн 3 дугаар хороонд 2022 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх шинэ авто замыг барьж, ашиглалтад оруулсны дараа нэршүүлэх ажлыг зохион байгуулна.	
2	2.12. Барилга, байгууламжид хаяг дугаар олгох ажлыг хариуцан гүйцэтгэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, e-mongolia.mn-ээр ирүүлсэн хаяг дугаар хүссэн 727 хүсэлтийг хүлээн авч 1051 барилгад шинээр, 132 барилгад дахин тодорхойлолт олгов. /28 653 830 төг/	100
3	2.13. Барилга байгууламжийн тэг тэнхлэгийн актыг мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэж Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх 208 хүсэлтийн 487ш блок барилга, байгууламжийг төлөвлөлтийн мэдээллийн санд бүртгэж, 165 актаар хүлээж авав.	100
	2.14. Гүйцэтгэлийн байр зүйн зургийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авч бүртгэн мэдээллийн сангийн суурь өгөгдлийг шинэчлэх, баяжуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний байр зүйн зургийг мэдээллийн санд хүлээлгэн өгөх 902 хүсэлтийг хүлээн авч, хот байгуулалтын суурь өгөгдлийг 270.0 га талбайгаар шинэчлэн баяжуулж, 596 акт үйлдсэн.	100
4	2.15. Хот байгуулалтын мэдээллийн сан дах зураг болон тоон мэдээ, мэдээллээр холбогдох журмын дагуу үйлчилгээ үзүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	1. Цахилгаан дамжуулах Үндэсний сүлжээ ТӨХК, Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар	

					<p>Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Нийслэлийн Замын хөгжлийн газартай байгуулсан “Хот байгуулалт, хөгжлийн газрын албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай” гэрээний дагуу 1:5000 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг (155 планшет), НХОГ-т 3x3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт хийх 14 байршлын байр зүйн зургийг тоон байдлаар хүргүүлсэн. тоон хэлбэрээр тус тус хүлээлгэн өгөв.</p> <p>2. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Монгол улсын Харилцаа Холбооны зохицуулах хороо, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд “Газарзүйн мэдээлэл хүлээлгэн өгөх, солилцох, хамтран ажиллах” тухай гэрээнүүдийг байгуулж нийт орон зайн 98 төрлийн мэдээллийг хүлээлгэн өгөв.</p> <p>3. НҮБ-ын Ази, номхон далайн бүсийн Эдийн засаг нийгмийн зөвлөлийн “Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бодит болгох Инчеоны стратеги”-ийн ажлын хүрээнд үндэсний түвшин боловсруулахад шаардлагатай суурь судалгаанд шаардлагатай хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэлтэй засгийн газрын 181ш барилгын мэдээллийг Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт өгсөн.</p>	100
--	--	--	--	--	--	-----

					<ul style="list-style-type: none"> • Ажлын хэрэгцээнд зориулан Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Одсүрэнд, 23 төрлийн мэдээллийг Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид 3 төрлийн мэдээллийг, Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг боловсруулах ажлын хүрээнд МУИС-д одоо байгаа болон төлөвлөлтийн авто зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, хаяг дугаар авсан бүртгэлтэй барилгын мэдээллийг, Цахим хөгжил, мэдээлэл технологийн газарт 2015-2021 онд ашиглалтанд орсон 878ш орон сууцны мэдээллийг, Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгжийн хүсэлтийн дагуу өгөгдсөн трассд орсон барилга, байгууламжийн мэдээллийг тоон байдлаар өгсөн. 4. НҮНТ, E-mongolia.mn-ээр инженерийн шуам, сүлжээний зурган мэдээлэл авах 53 хүсэлтийг хүлээн авч, 72 байршилд нийт 8 891 201 төгрөгийн байр зүйн зургийг гаргаж өгсөн. 5. Гамшгийн үед түр орон байраар хангах албанд 2.8x1.8м хэмжээтэй сэдэвчилсэн зураг 2 хувь, Г.Төгөлдөр төлөөлөгчид Сонгинохайрхан дүүргийн 30, 31, 43 дугаар хорооны сэдэвчилсэн зураг, НУБГ-т гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, сургалтын үед хэрэглэх Улаанбаатар хотын 1.8мx2.8м хэмжээтэй ажлын зураг, НБИХГ-т Улаанбаатар хотын 1.8мx2м хэмжээтэй сэдэвчилсэн зургуудыг тус тус бэлтгэн хэвлэж өгсөн. 	
--	--	--	--	--	---	--

5	2.16. Хот байгуулалтын мэдээллийн сан дах орон зайн дэд мэдээллийн сангийн өгөгдлийн шинэчлэх, баяжуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ol style="list-style-type: none"> 1. Шинээр хаяг дугаар авсан 1001 барилгын 25-69 төрлийн мэдээллээр барилгын дэд мэдээллийн санг баяжуулав. 2. АТД, загвар зураг батлагдсан Төлөвлөгдсөн барилгаас “Устгах” төлөвтэй нийт 222ш барилгын мэдээллийг арилгаж, суурь мэдээллийг шинэчилсэн. /ХУД-151, СБД-15, ЧД-15, БГД-13, БЗД-11, Алс-2, СХД-15/ 3. Байнгын ашиглалтад оруулах улсын комисс хүлээж авсан, давхарлаж оруулсан зэрэг нийт 2422ш төлөвлөлтийн барилгын мэдээллийг устгаж, шинэчилсэн. 4. Байр зүйн зургаар хүлээлгэн өгсөн 5.6 км авто зам, 11.8 км цахилгааны шугам, 28,8 км дулааны шугам, 6.5 км ариутгах татуурга, 9.1 км усан хангамжийн мэдээллээр дэд сангуудын өгөгдлийг шинэчлэв. 5. Дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цэгэн мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. 6. Хот байгуулалтын мэдээллийн санд байр зүйн зургаар хүлээлгэн өгсөн 49.3 км авто зам, 66.3 км цахилгааны шугам, 36.2 км дулааны шугам, 19.1 км ариутгах татуурга, 20.1 км усан хангамж, 7,8 км холбооны шугамын мэдээллээр дэд сангуудын өгөгдлийг шинэчлэв. 7. Цахилгаан дамжуулах Үндэсний сүлжээ ТӨХК-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Их тойруу 110кВ-ын ЦДАШ-ын Дүнжингарав дэд станцаас Сонгино дэд станц хүртэлх хэсгийн хамгаалалтын зурвасыг шинэчлэв. 	100
---	--	---	---------------------------------	-----	-----	--	-----

						<p>8. Орон зайн мэдээллийн санг шинэчлэх ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн хороодын заагийн өөрчлөлтийн мэдээллээр хороодын нутаг дэвсгэрийн дэд мэдээллийн санг шинэчлэв.</p> <p>9. Хот байгуулалтын мэдээллийн сан дахь цэцэрлэг, шатахуун түгээх станц, зах, худалдааны төв, худалдаа үйлчилгээний төвийн мэдээллийг шинэчилсэн.</p> <p>10. Тэрэлж тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хил, төлөвлөсөн авто замын мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд оруулсан.</p>	
6	<p>2.17. Байгууллагын гадаад болон дотоод сүлжээний зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, сервер, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, хот байгуулалтын мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, нөөцлөх ажлыг зохион байгуулах</p>		<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	100	<p>1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Дуламсүрэнгийн хамт акт үйлдэн устгаж, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт албан бичгээр актыг хүргүүлэн ажиллав.</p> <p>2. Хан-Уул дүүрэг дэх Нутгийн захиргааны 4 дүгээр байранд нүүж ирсэнтэй холбогдуулан хурлын заал, нэгжүүдийн нийт 15 ерөөний дотоод сүлжээ, серверийг бүрэн холбож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>3. Хууль, эрх зүйн хэлтсийн 7 компьютер, дагалдах тоног төхөөрөмжүүд, иргэд хүлээн авах угтах үйлчилгээний 2 компьютер, хуруу бүртгэлийн төхөөрөмжийг дотоод сүлжээнд холбон хэвийн ажиллагааг хангасан.</p>	100

					<ol style="list-style-type: none">4. Байгууллагын дотоод сүлжээнд шинээр томилогдсон 19, ажлаас чөлөөлөгдсөн 15 албан хаагчдын нэвтрэх, хандах эрхийг тогтоосон.5. Шинээр байгуулагдсан 2 хэлтсийн дотоод сүлжээ болон цахим баримт бичгийн хавтасуудыг нээж хандах эрхийг тохируулан ажиллав.6. Дуудлагаар үйлдлийн систем дахин суулгах-11, принтер холбох-96, ажлын хэрэгцээний программ хангамж суулгах-103 ажлыг хийж гүйцэтгэв.7. Байгууллагын сервер, сүлжээний тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг хангах болон хадгалалт хамгаалалтыг сайжруулах, программ хангамж, техник хангамж, эд анги, дотоод сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.8. Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын дагуу мэдээллийн аюулгүй байдлыг Фортинэт загварын галт хана болон домайн контроллер дээр зөвшөөрөлгүй вэб хуудас болон зөвшөөрөлгүй програмуудыг хязгаарлах арга хэмжээ авч ажиллав.9. Цаг бүртгэлийн машинаас албан хаагчдын мэдээллийг өдөр бүр татаж UBERP системд оруулж байна.10. Албан хаагчдын техник, тусламжийн цахим бүртгэлийн цэсийг нээж тус бүртгэл дээр дүн шинжилгээ хийх, ашиглалтыг сайжруулахаар ажиллаж байна.11. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/217 дугаар захирамжийн дагуу нийт албан хаагчдын цаг бүртгэлийг шинэчлэв.12. Байгууллагын цахим баримт бичгийн 11ТВ хэмжээтэй серверийн багтаамж	
--	--	--	--	--	--	--

						<p>дүүрсэнтэй холбоотой хэлтсүүдийн дотоод ажлын хавтсуудыг өөр серверлүү шилжүүлж 6ТВ хэмжээг цэгцлэв.</p> <p>13. Үндэсний дата төв болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамд Төрийн нэгдсэн ХУР, Дан системд холбогдох хүсэлтийг албан бичгээр хандсан.</p> <p>14. Мэдээллийн аюулгүй байдлын газарт төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох хүсэлтээ албан бичгээр хүргүүлж холбогдох тоног төхөөрөмж, сэлбэгийг бэлтгэж байна.</p>	
7	<p>2.18. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн өгөгдлийн баазыг шинэчлэх, хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих.</p>		<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	100	<p>1. Системийн өгөгдөл мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэн ажиллаж байгаа ба домэйн болон давхаргын шинэчлэлт:</p> <ul style="list-style-type: none"> • Хот байгуулалтын төлөвлөлт давхаргын LRT трасс • Хэлтсүүдийн үйл ажиллагаан хил хуваалт • Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө дэд давхаргын ХЕТ бүсчлэл • ХЕТ хил хязгаар • Бүх прожектэд Барилгажихыг хориглосон бүс, Хүн амын нягтрал хэтэрсэн байршил зэрэг дэд давхаргуудыг устгасан. • Хаягийн бүс домэйн сонголтын утгуудыг цэгцэлсэн • Байгуулагын шинэ бүтэц зохион байгуулалттай холбоотойгоор хэвлэх дэд програмын загваруудыг шинэчилсэн. <p>2. Албан хаагчдын хандах эрх:</p> <ul style="list-style-type: none"> • Архитекторуудад бүх дүүрэгт төлөвлөлтийн барилга, тохижилт, дэд бүтэц нэмэх, хандах эрх нээсэн. 	100

						<ul style="list-style-type: none"> • Барилга байгууламжийн чанарын хэлтсийн мэргэжилтнүүдээс барилга ажил эхлэх зөвшөөрөл бүртгэх эрхийг хасаж Хот байгуулалтын инженерийн бэлтгэл, хяналтын хэлтсийн 2 мэргэжилтэнд уг хандах эрхийг нээсэн. • Суурь мэдээлэлтэй холбоотой орон зайн болон атрибут мэдээлэлд хандах 4 албан хаагчийн хандах эрхийг үүсгэсэн. <p>3. Дэд програм хангамжийн шинэчлэлт, өгөгдлийн баазын хадгалалт хамгаалалт:</p> <ul style="list-style-type: none"> • ХБММС болон түүнтэй холбогдон ажилладаг бусад дэд програм хангамжуудын өгөгдлийн 9 баазыг 2022 оны 5 сарын байдлаар, цахим хуудас болох uda.ub.gov.mn өгөгдлийн баазыг 1 тус тус нөөцлөн авсан. • “Цахим бүртгэлийн програм” хангамжийг хот байгуулалтын мэдээллийн системд холбон үйл ажиллагаанд хэрэглэхэд бэлэн болсон. • ХБММС-н барилга байгууламжийн мэдээллийн санд бүртгэгдсэн өгөгдлийг PostgreSQL/QGIS х ө р в • Үргэн, аж ахуй нэгж байгууллагаас мрүүлсэн албан бичиг материалууд олддоггүй, ямар мэргэжилтэн дээр ж р
--	--	--	--	--	--	--

						4. Газрын даргын №Т2022/01 удирдамжийн дагуу зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэгдсэн байдлыг хэдэн хувийн бүрдэлтэй байгаа талаар хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэв.	
8	2.19. Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, мэдээ мэдээллийг шинэчлэх.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<p>1. Тайлант хугацаанд байгууллагын http://uda.un.gov.mn цахим хуудсанд 12 төрлийн 120 мэдээ мэдээллийг шинэчилсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ – 1 • Үйл ажиллагааны төлөвлөгөө – 10 • Санхүүгийн мэдээ – 10 • Мэргэжлийн зөвлөлийн хурлын мэдээ – 38 • Барилгын ажлын зөвшөөлийн гэрчилгээ олгосон мэдээ – 10 • Цаг үеийн мэдээ – 10 • Хүний нөөцийн мэдээ – 6 • Бүтэц, зохион байгуулалтын мэдээ – 11 • Тендерийн урилга – 2 • Ирсэн, явсан бичгийн мэдээ – 4 • Үйлчилгээний бүрдүүлэх материал – 23 <p>2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” боловсруулан газрын даргаар батлуулав.</p> <p>3. Байгууллагын зарим үйлчилгээ e-mongolia.mn холбогдсон талаар мэдээлэл бэлтгэн байгууллагын</p>	100

						www.uda.ub.gov.mn цахим хуудас болон facebook хуудсанд байршуулсан.	
<i>Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:</i>							
1	3.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	1. Нийслэлийн засаг даргын 2021 оны А/987 дугаартай "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамжийн биелэлтийг гаргасан. /5 удаа/ 2. 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Цахим хөгжил, хууль, эрх зүй, төрийн үйлчилгээний асуудал хариуцсан орлогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлтийг 1 удаа гаргаж өгсөн.	100
2	3.2. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 6 дугаар хавсралтын дагуу албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна. 2. Нэгжийн дүрэмд санал өгч, шинэчилсэн. 3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд санал өгсөн. 4. Орон зайн мэдээллийн сан хариуцсан, Цахим шилжилт хариуцсан ахлах мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн. 5. Тус газар Барилга.мн-тай хамтран 5 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулсан "BARILGA EXPO 2022" үзэсгэлэн, яармагт хот байгуулалтын хөгжлийн газрын цахим үйлчилгээний талаарх танилцуулга хийсэн.	100

						6. МУ-ын Харилцаа, Холбооны зохицуулах хорооноос зохион байгуулж байгаа Хаягжилтын өнөөгийн байдал, зипкодны хэрэглээ сэдэвт сургалтыг Газрын харилцаа, Геодези зураг зүйн газартай хамтран 9 дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харъяа байгууллагуудын 750 гаруй албан хаагчдад танхимаар болон цахимаар хийгээд байна.	
3	3.3. Хэлтсийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ol style="list-style-type: none"> 1. Нэгжээс үзүүлж байгаа үйлчилгээний хяналтын хуудсыг шинэчилсэн. 2. Программ хангамж хариуцсан мэргэжилтэн Э.Насанбатын боловсруулсан байгууллагад ирсэн хүсэлтийг бүртгэх дэд программын талаарх танилцуулгыг Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулав. 3. Тус байгууллагаас хэрэгжүүлэхээр төлөвлөвлөж буй ажлын талаарх товч танилцуулга, мэдээллийг тухай бүрд бэлтгэн Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны холбогдох мэргэжилтэнд монгол, англи хэл дээр хүргүүлсэн. 	100
	3.8. “Авлигын эсрэг үндэсний чуулган”-аас гаргасан Зөвлөмж 2.8. Цахим засаглалыг хөгжүүлэх, e-mongolia цахим системээр үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ авахад нэн шаардлагатай тоон бичиг үсгийн чадвартай иргэнийг бэлтгэхэд онцгойлон анхаарах, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, иргэд төрөөс үйлчилгээ авдаг жишгээс төр иргэддээ үйлчилгээ санал болгодог хэлбэрт шилжих.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ol style="list-style-type: none"> 1. Хэлтсийн дарга А.Амарсанаа, орон зайн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Уранбайгаль, цахим шилжилт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Баярмаа нар 2021 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд нь мэдүүлж, баталгаажуулсан. 2. НЗДТГ-аас Авлига хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын дүгнэлтийн хариу арга хэмжээний жилийн ажлын төлөвлөгөөнөөс 	100

					<p>хэлтэст хамаарах заалтын биелэлтийг гаргасан.</p> <ol style="list-style-type: none">3. УИХ-ын дэргэдэх цахим хөгжлийн байнгын хороо нийслэлд ажиллах болсонтой холбоотойгоор тус байгууллагаас 2022 онд хэрэгжүүлэх ажлын танилцуулгыг Цахим хөгжил, мэдээлэл технологийн газарт хүргүүлсэн.4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан “UB engineering” системийн ажлын явц, цаашид хийгдэх ажлын талаарх уулзалтад оролцож холбогдох санал өгсөн.5. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газартай хамтран 2022 онд хэрэгжүүлэх “Онлайн бизнес төв”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтарсан уулзалтад хийж холбогдох байгууллагуудаас санал авсан.6. НЗДТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам, Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хийх журам, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журмын төсөлд тус тус санал хүргүүлсэн.	
--	--	--	--	--	---	--

		Албан бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэлтийг чанаржуулах	-	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	Иргэн, хуулийн этгээдээс https://edoc.ulaanbaatar.mn/ цахим хуудсаар нийт албан бичиг ирсэнээс 114 албан бичигт хугацаанд нь хариу өгч, 1 албан бичигт хариу өгөхөөр хүлээгдэж байна. /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.95 хоног/	
	Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	3.10.4 Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлах - Ирсэн бичгийн бүртгэл хяналтын картыг хэвлэх, цахимаар ирсэн бичгийг бүртгэл хяналтын картын хамт EDOC системээс хэвлэн, архивлах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	100	Ирсэн 114, явуулсан 67 албан бичиг, 791 хаягийн тодорхойлолтыг албан бичгийн бүртгэл, хяналтын картын хамт хэвлэж архивлаж байна.	100
		3.10.5 Албан бичгийн цахим архив үүсгэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	9 хоног	8 хоног	Нэгжийн ирсэн, явсан бичгийн хавтсанд цахим архив үүсгэн, архивлаж байна.	
	Өргөдөл гомдлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	Шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	Иргэн, хуулийн этгээдээс www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсаар ирүүлсэн 16 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн 15, судалж байгаа 1 өргөдөл байна. /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног/	100
7	3.16 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх			Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	1. Нэгжээс 2021 оны нийт 96 боть баримтыг байгууллагын архивт хугацаанд нь хүлээлгэн өгсөн. 2. Геодези, зураг зүйн тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу 2021 онд хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгсөн 7 боть байр зүйн	100

						зургийн эх материал, тоон мэдээллийн Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Улсын нэгдсэн сангийн архивд хүлээлгэн өгөв. 3. Геодези, зураг зүйн тухай хуулийн 9.2 заалтын дагуу Улсын нэгдсэн сангийн архивт Хот байгуулалтын байр зүйн зургийн мэдээллийн санд бүртгэгдсэн, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар хийгдсэн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний байр зүйн дэвсгэр зургийн эх материал болон тоон мэдээллийг хүлээлгэн өгсөн.	
<i>Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд:</i>							
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтцийн чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ.							
1	4.1 Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд I-UP мэдээллийн цонхыг тогтмол ажиллуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	1. Барилгад хаяг дугаар олгох, мэдээллийн санд бүртгэх, Архитектур төлөвлөлтийн даалгавар олгох, Барилгын ажлын эхлүүлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний хүсэлтийг цахимаар илгээх зааврын I-UP видео эвлүүлэг хийсэн.	100
2	4.4 Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах хүрээнд байгууллагаас үзүүлдэг зарим үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia-д холбоно.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	10	20	1. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбогдох болон байгууллагаас үзүүлдэг үзүүлдэг бусад үйлчилгээг e-mongolia.mn-д холбох талаар E-Mongolia академийн дарга н.Энхбат, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзсан холбогдох санал солилцсон. 2. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-Mongolia системд Загвар зураг батлах үйлчилгээг оруулахтай холбоотойгоор зураг зөвшилцөх албан хаагчдын холбогдох мэдээллийг нэгтгэн E-Mongolia академийн хариуцах мэргэжилтэнд хүргүүлсэн.	100

					<p>3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газартай хамтран 2022 онд хэрэгжүүлэх “Онлайн бизнес төв”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтарсан уулзалт хийж холбогдох саналыг хүргүүлсэн.</p> <p>4. “Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний үр дүнг бодитой үнэлж дүгнэх, үйлчилгээг дахин загварчилж хүнд суртал, чирэгдлийг арилгаж эрх зүйн орчныг боловсронгуй болгох” зорилго бүхий Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/60 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт гишүүнээр хэлтсийн дарга А.Амарсанаа, нарийн бичгээр цахим шилжилт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Баярмаа ажиллаж, доорх ажлыг гүйцэтгэн мэдээллийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтанд хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Онлайн бизнес төв”-ийн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч “Систем арт винчерс” ХХК-н холбогдох албан хаагчид болон хэлтсүүдийн ахлах мэргэжилтнүүдтэй хамтарсан уулзалт хийж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны талаар танилцуулсан. • Газраас иргэн, хуулийн этгээдэд өдөр тутамдаа үзүүлдэг 22 үйлчилгээний өнөөгийн шат дамжлага, үйлчилгээний процесс, бүрдүүлэх материалын жагсаалт, эрх зүйн үндэслэл, хэд хоногт шийдвэрлэдэг талаарх мэдээлэл,
--	--	--	--	--	---

						<ul style="list-style-type: none"> • Мөн 22 төрлийн үйлчилгээг Барилгын зөвшөөрөлтэй холбоотой болон Бусад гэсэн 2 бүлэг 8 төрөл болгон нэгтгэх, дахин зохион байгуулах саналыг схем хэлбэрээр гаргаж, • Ажлын хэсгийн хүрээнд шийдвэрлэх арга зам, үйл ажиллагааг сайжруулахад боломжтой • Бүрдүүлэх материалын жагсаалтыг багасгах саналыг үйлчилгээ тус бүрээр гарган, <i>Тухайлбал</i>, Барилга барих хүсэлт илгээхэд бүсээсээ хамаараад 8-9 төрлийн баримт бичиг бүрдүүлдэг байсныг 5 төрөл болгож, Загвар зураг батлах үйлчилгээнд 10 төрлийн баримт бичиг шаарддаг байсныг 3 төрөл, Шугам сүлжээний зураг зөвшилцөхөд 8 төрлийн баримт бичиг бүрдүүлдэг байсныг 5 төрөл, Тэг тэнхлэг мэдээллийн санд бүртгэхэд 6 төрлийн баримт бичиг бүрдүүлдэг байсныг 3 төрөл болгох саналыг тус тус гаргаж бүрдүүлэх материалыг 50 хувиар бууруулах санал, • Мөн тус байгууллага нь төрийн нэгдсэн сүлжээ ХУР-д холбогдсон тохиолдолд дээрх бүрдүүлэх баримт бичгүүд дахин 50 хувиар багасах боломжтой талаарх санал, • “Онлайн бизнес төв”-ийн систем хөгжүүлэлтийн ажил хийгдэж эхэлсэнтэй холбоотойгоор үйлчилгээ авах шаардлагын товч тайлбарыг тус тус гаргасан. <p>Мөн дээрх ажилтай холбоотойгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын</p>
--	--	--	--	--	--	---

						газар, нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газраас 3 дугаар сарын 10, 12, 5 дугаар сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулсан хурал, уулзалтад оролцсон.	
	Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвүүд болон e-mongolia-н хүсэлт хүлээн авах албан хаагчдад үйлчилгээний талаарх сургалт зохион байгуулах	-	Сургалтын тоо	-	1 сургалт зохион байгуулсан байна	1. 03 дугаар сарын 18-ны өдөр тус газар e-mongolia.mn системийг хөгжүүлэгч “Аствишн” ХХК-тай хамтран байгууллагаас цахимаар үзүүлж байгаа 9 үйлчилгээний материалын бүрдэл, шийдвэрлэх хугацаа болон холбогдох асуудлуудын талаар Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний 32 операторт хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Уранбайгаль, мэргэжилтэн Б.Алтансоёмбо, С.Пүрэв-Очир нар танилцуулга, сургалт хийсэн.	100

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	мэргэшил,	Хүрэх түвшин	Хэрэгжүүлсэн ажил	Эхлэх, дуусах огноо
1	2		3	4	5
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1	Арга хэмжээ №3.13.1 Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинээр мэргэжил эзэмших, мэргэшүүлэх сургалтад хамрагдах		Сургалтанд хамрагдсан нийт 40 цаг	Удирдлагын академаас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын сургалтанд Орон зайн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Уранбайгаль хамрагдаж №22/0554 дугаартай үнэмлэх авсан.	04.16-04.25

		6 бүлэг 24 цагийн хичээл	Төрийн албаны мэдээлэл технологийн ажилчдад зориулсан мэдээллийн аюулгүй байдлын сургалтад Мэдээллийн технологийн мэргэжилтэн Б.Алтансоёмбо хамрагдсан.	06.13-06.17
		36 сэдэв 12 цагийн хичээл	Харилцаа, Холбоо, Мэдээллийн технологийн Салбарын мэргэжилтэнд зэрэг олгох сургалтанд Програм хангамж хариуцсан мэргэжилтэн Э.Насанбат хамрагдаж, 2 дахь сунгалтаа хийсэн.	2021.12.01-2022.01.15
		Ажлын өдрүүдээр ажлын бус цагаар	Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуульд Санхүүгийн магистраар Хот төлөвлөлтийн мэргэжилтэн П.Цэрэндолгор суралцаж байна.	02.15-05.30
2	Арга хэмжээ №3.13.2.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан нийт 22 цаг, /Пүрэв гариг бүр/	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10” арга зүйн багц сургалтад нийт албан хаагчид тогтмол хамрагдаж байна.	01.02-06.17
3	Арга хэмжээ №3.13.3.Газрын хэмжээнд зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд хамрагдах	Сургалтад хамрагдсан нийт 3 цаг	Залуучуудын зөвлөлөөс зохион байгуулж буй “Монгол бичиг”-н сургалтанд Цахим шилжилт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Баярмаа, Хот төлөвлөлтийн мэргэжилтэн П.Цэрэндолгор нар хамрагдаж байна.	06.07-с

ГУРАВ. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4
1	Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санд суурилсан “Ковид-19 халдварын тархалтын орон зайн мэдээлэлд суурилсан бүртгэл, хяналт, төлөвлөлт”-ийн системийг хөгжүүлж удирдлагын оновчтой шийдвэр гаргахад НОК-т дэмжлэг үзүүлж ажиллах.	Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 08 дугаар тушаал	1. Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт амралтын өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Жамц, Хот төлөвлөлтийн мэргэжилтэн П.Цэрэндолгор нар ажилласан. 2. НЗД-ын жуух бичгээр П.Цэрэндолгор, Нийслэлийн тэргүүний ажилтанаар Т.Жамц нар шагнуулсан.
2	Хан-Уул дүүргийн 9, 10 дугаар хорооны түүхий нүүрсний хэрэглээ, сайжруулсан түлшний хяналт, вакцинжуулалтын ажилд хяналт тавьж ажиллах.	Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаал	1. Нийт албан хаагчид Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны 7, 8 дугаар хэсгийн ахлагч, бусад албан хаагчидтай хамтран түүхий нүүрсний хэрэглээ, сайжруулсан

			түлшний хүртээмж, зуух, утаа мэдрэгчүүдийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт тайлан мэдээг нэгтгэн хүргүүлж ажилласан.
3	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах “Хотын иргэний жил”-ийн танилцуулга, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх.		1. Нийт албан хаагчид 2022 оныг “Хотын иргэний жил” болгохтой холбогдуулан Улаанбаатар хотын амьдрах орчны болон иргэний аюулгүй байдлын талаар судалгаа, танилцуулга хийж ажилласан.
4	Нийслэлийн хүн амын нягтралыг нэгж хорооллын төлөвлөлттэй уялдуулан судалгаа хийх		1. Нийслэлийн хүн амын нягтрал Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, нэгж хорооллын төлөвлөлөөс хэтэрсэн байдлын судалгаа, танилцуулга бэлтгэсэн. 2. ЕААА-ны төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэнд холбогдох судалгааны материал, зураглал, танилцуулгыг өгсөн.
5	“Сонсголонт хот” төслийн судалгаа, төлөвлөлтийн ажилд дэмжлэг үзүүлэх.		1. Суурь судалгаа, төлөвлөлтийн ажилд тусгаарлагдан ажиллаж, 4.4x2.2м хэмжээтэй сэдэвчилсэн зураг бэлдэж, хэвлэн байршуулсан. 2. “Сонсголонт хот” төслийн суурь судалгаа, төлөвлөлтийн ажилд дэмжлэг үзүүлж мэдээ, мэдээлэл гаргаж, сэдэвчилсэн зураг бэлтгэж, хэвлэж ажилласан.
6	Орц, гарц чөлөөлөх судалгааны ажлын хүрээнд		1. Барилгажсан хэсгийн одоо байгаа болон төлөвлөлтийн авто замын мэдээлэл бүхий 1.8*3м хэмжээтэй зураг бэлдэж, хэвлэсэн.
7	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах судалгаа хийх	Ерөнхий архитекторын шуурхай үүрэг даалгавар	1. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн ногоон бүс дэхь дөрвөн улирал амьдардаг айл өрхийн судалгаа гаргасан. 2. Мөн Их тойруу дахь төрийн байгууллагын тоог зориулалтаар, барилгын насжилтаар, нэгж талбараар, хамрах хүрээгээр тус тус судалгаа гаргаж, холбогдох зургийн хамт ЕААА-нд өгөв. 3. Хан-Уул дүүргийн Яармагийн Хүннү молл худалдааны төвөөс баруун тийш Буянт ухаа цогцолбор хүртэлх нийт 6км авто замын урд, хойд хэсгээр LRT-ын төлөвлөлтийн трассд өртөж байгаа ногоон байгууламж, барилга, байгууламжийн тоог газар дээр нь явж судалгаа хийн танилцуулга бэлдэж өгсөн.
8	Ub city tour online төслийн судалгаа		1. Цахим аялал, түүний маршрутын талаар судалгаа, танилцуулга бэлдэж, цаашид хэрхэн шийдвэрлэж болох талаар шийдэл гаргаж танилцуулсан.

			2. Google map платформ-д мэдээлэл оруулах заавар, 360 камерын үнийн санал, үзүүлэлтийг гаргасан.
9	Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад орчны аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай	НЗД-ын захирамжийн ажлын хэсэг	<ol style="list-style-type: none"> 1. Сүхбаатар дүүргийн хороодуудад Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 2, Хотын Стандарт Хяналтын газрын мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Програм хангамж хариуцсан мэргэжилтэн Э.Насанбат ажилласан. Уг ажлын үр дүнд НЗД-ын 2022.04.26 өдрийн А/572 тоот “Эрүүл орчин бүрдүүлэх тухай” захирамж гарсан. 2. НЗД-ын 2021 оны А/908 тоот захирамжаар байгуулагдсан “Тэр бум” мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хүрээнд 02 дугаар сарын 15-ны өдөр төв Хангарьд ордонд, Ногоон хот-Иргэний оролцоо” нийслэлийн зөвлөгөөнд 03 дугаар сарын 28 өдөр Орон зайн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Уранбайгаль тус тус оролцсон.
10	Газрын даргын үүрэг даалгавар	Ажлын хэсэг	<ol style="list-style-type: none"> 1. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын тушаалаар байгуулагдсан “Газар зүйн нэрийн зөвлөл”-д хэлтсийн дарга А.Амарсанаа ажиллаж байна. Мөн “Газар зүйн нэрийг тогтоох, тодотгох, солбицолжуулах, газар зүйн нэрийн зураг үйлдэх дүрэм”-д санал өгсөн. 2. Газрын даргын 2022 оны А03 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах эрсдлийн үнэлгээ хийх” ажлын хэсэгт геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Пүрэв-Очир ажиллаж байна. 3. Газрын даргын 2022 оны А/05 дугаар тушаалаар батлагдсан “Спорт хамтлаг”, А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ёс зүйн зөвлөлийн шинэчлэн батлах тухай” ажлын хэсгүүдэд мэдээлэл, технологийн мэргэжилтэн Б.Алтансоёмбо орж ажиллаж байна. 4. Газрын даргын 2022 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “Сэтгэл ханамжийн байдлыг судлах судалгааны баг”-ийн ахлагчаар Цахим шилжилт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Баярмаа ажиллаж байна. 5. Газрын даргын 2022 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ын гишүүнээр Орон зайн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Уранбайгаль ажиллаж байна.

			<p>6. Газрын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан “Өмч хамгаалах ажлын хэсэг”-ийн гишүүнээр П.Цэрэндолгор ажиллаж байна.</p> <p>7. Газрын даргын 2022 оны А/24 дугаар тушаалаар батлагдсан “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн гишүүнээр П.Цэрэндолгор ажиллаж байна.</p> <p>8. Газрын даргын 2022 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Архивын баримтад нягтлан шалгалт хийх ажлын хэсэг”-ийн гишүүнээр Орон зайн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Уранбайгаль, Хот төлөвлөлтийн мэргэжилтэн П.Цэрэндолгор нар ажиллаж байна.</p> <p>9. Газрын даргын 2022 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Эд хөрөнгийн тооллогын комисс”-ийн гишүүнээр Програм хангамж хариуцсан мэргэжилтэн Э.Насанбат ажиллаж байна.</p> <p>10. Монголын эдийн засгийн чуулган “Хот, хөдөөгийн сэргэлт” урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж ажилласан.</p>
--	--	--	---

Төлөвлөгөөг үнэлсэн:
 Газрын дарга
 (албан тушаал)
 Тэмдэг

Төсвийн шууд захирагч
 /Ц.Тулга/
 (гарын үсэг)
 (огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
 Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
 (албан тушаал)

Нэгжийн дарга
 /Ч.Бадамханд/
 (гарын үсэг)
 (огноо)

Тайлагнасан:
 Хот байгуулалтын мэдээллийн
 хэлтсийн дарга
 (албан тушаал)

Нэгжийн дарга
 /А.Амарсанаа/
 (гарын үсэг)
 (огноо)